БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БӨА-2025/057/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баян-Өлгий аймаг<br>2023 он | Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл<br>Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn<br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 99932710 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>Аудитор: Х.Манаргүл<br>Утас: 95429524 Цахим хаяг: manargulx@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ........ 4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ........ 6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ........ 12
4. АУДИТЫН ТАЙЛАН ........ 17
4.1 Ерөнхий зүйл ........ 17
4.2 Материаллаг байдал ........ 17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ........ 17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 18
4.5.1 Завсрын аудитын талаар ........ 18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ........ 18
5.1 Төлбөрийн акт ........ **Error! Bookmark not defined.**
5.2 Албан шаардлага ........ **Error! Bookmark not defined.**
5.3 Зөвлөмж ........ **Error! Bookmark not defined.**
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ........ 19

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

2025.02.18 № 69

танай ______ -ны № ______ -т

НОГООННУУР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 1 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Ш.РАЯ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд онцлох үйл явдал гараагүй байна.

**Аудитын гол асуудал**

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

83250200041

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.АЙГҮЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **668,338,673.00** | **742,017,717.00** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 289,870,582.00 | 315,596,124.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 289,870,582.00 | 315,596,124.00 |
| **3121** | **Төгрөг** | 289,870,582.00 | 315,596,124.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 289,870,582.00 | 315,596,124.00 |
| **33** | **АВЛАГА** | 32,602,000.00 | - |
| **335** | **Бусад авлага** | 32,602,000.00 | - |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 32,602,000.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 345,866,091.00 | 426,421,593.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 311,706,091.00 | 395,691,593.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 191,890,635.00 | 231,575,844.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 14,825,066.00 | 9,782,166.00 |
| 35460 | Хүнсний материал | 59,963,655.00 | 79,805,372.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 45,026,735.00 | 74,528,211.00 |
| 35600 | Мал амьтад | 34,160,000.00 | 30,730,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,705,147,160.77** | **2,036,986,846.04** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,705,147,160.77 | 2,036,986,846.04 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,625,178,083.80 | 1,960,782,016.91 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,820,677,451.38 | 2,015,354,451.38 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (408,963,759.49) | (504,764,141.82) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 171,342,976.00 | 415,584,421.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (64,294,014.28) | (115,135,604.53) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 74,696,915.00 | 124,150,895.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (42,988,671.73) | (48,804,079.96) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 8,000,000.00 | 8,000,000.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (311,111.08) | (622,222.16) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 66,199,327.00 | 66,199,327.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (66,199,327.00) | (66,199,327.00) |
| 39217 | Ном | 67,018,298.00 | 67,018,298.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 79,969,076.97 | 76,204,829.13 |
| 39301 | Програм хангамж | 18,821,239.00 | 18,821,239.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (456,162.03) | (4,220,409.87) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 61,604,000.00 | 61,604,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,373,485,833.77** | **2,779,004,563.04** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,373,485,833.77** | **2,779,004,563.04** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,373,485,833.77 | 2,779,004,563.04 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 471,200,088.00 | 471,200,088.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 471,200,088.00 | 471,200,088.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 507,220.89 | 406,025,950.16 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 507,220.89 | 507,220.89 |

| | | | |
|---|---|---|---|
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 405,518,729.27 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,901,778,524.88 | 1,901,778,524.88 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,373,485,833.77** | **2,779,004,563.04** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **3,156,976,036.00** | **4,573,097,112.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **39,133,250.00** | **88,127,087.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 39,133,250.00 | 88,127,087.00 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 39,133,250.00 | 88,127,087.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,200,000.00 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 8,000,000.00 | 9,991,080.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 28,933,250.00 | 78,136,007.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **3,117,842,786.00** | **4,484,970,025.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 3,117,692,138.00 | 4,408,602,025.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 75,968,000.00 | 4,031,495,100.00 |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | 94,704,338.00 | 377,106,925.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 2,947,019,800.00 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 150,648.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 150,648.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | - | 76,368,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 76,368,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,837,627,795.28** | **4,167,578,382.73** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,837,627,795.28** | **4,167,578,382.73** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,743,195,160.28 | 4,023,378,594.73 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,014,845,235.00 | 3,048,186,917.00 |
| 210101 | Үндсэн цалин | 1,371,547,704.00 | 1,895,789,997.00 |
| 210102 | Нэмэгдэл | 542,859,735.00 | 1,048,242,962.00 |
| 210104 | Урамшуулал | 100,437,796.00 | 104,153,958.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 245,632,152.00 | 388,776,207.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 158,608,452.00 | 261,880,507.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 21,755,800.00 | 31,724,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 17,404,400.00 | 15,862,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,351,200.00 | 15,862,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 43,512,300.00 | 63,447,700.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 65,931,293.00 | 79,110,900.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,033,908.00 | 12,787,957.00 |
| 210302 | Түлш, халаалт | 56,897,385.00 | 66,322,943.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 202,902,265.00 | 208,735,455.00 |
| 210502 | Хоол, хүнс | 202,902,265.00 | 208,735,455.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,100,000.00 | 2,300,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,100,000.00 | 2,300,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 15,966,600.00 | 44,414,455.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,200,000.00 | 6,102,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 13,766,600.00 | 38,311,955.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 196,817,615.28 | 251,854,660.73 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 53,252,583.00 | 75,358,021.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 17,765,350.00 | 19,963,900.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 125,799,682.28 | 156,532,739.73 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 94,432,635.00 | 144,199,788.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 94,432,635.00 | 144,199,788.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 94,432,635.00 | 106,126,588.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 38,073,200.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **319,348,240.72** | **405,518,729.27** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **319,348,240.72** | **405,518,729.27** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **3,033,338,448.00** | **4,117,854,180.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **10,200,000.00** | **9,991,080.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 10,200,000.00 | 9,991,080.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 10,200,000.00 | 9,991,080.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,200,000.00 | |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 8,000,000.00 | 9,991,080.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **3,023,138,448.00** | **4,107,863,100.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 3,022,987,800.00 | 4,031,495,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 75,968,000.00 | 4,031,495,100.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 2,947,019,800.00 | |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 150,648.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 150,648.00 | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | - | 76,368,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | | 76,368,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **2,747,898,923.00** | **4,013,465,138.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,747,898,923.00** | **4,013,465,138.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,647,004,733.00** | **3,855,454,238.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,014,845,235.00 | 3,040,414,424.00 |
| 210101 | Үндсэн цалин | 1,371,547,704.00 | 1,888,017,514.00 |
| 210102 | Нэмэгдэл | 542,859,735.00 | 1,048,242,962.00 |
| 210104 | Урамшуулал | 100,437,796.00 | 104,153,948.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 245,632,152.00 | 396,548,700.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 158,608,452.00 | 269,653,000.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 21,755,800.00 | 31,724,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 17,404,400.00 | 15,862,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,351,200.00 | 15,862,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 43,512,300.00 | 63,447,700.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 74,868,000.00 | 74,068,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,033,908.00 | 12,787,957.00 |
| 210302 | Түлш, халаалт | 65,834,092.00 | 61,280,043.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 203,841,615.00 | 214,766,060.00 |
| 210502 | Хоол, хүнс | 203,841,615.00 | 214,766,060.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,100,000.00 | 2,300,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,100,000.00 | 2,300,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 15,910,600.00 | 45,434,455.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,200,000.00 | 6,102,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 13,710,600.00 | 39,331,955.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 90,807,131.00 | 81,922,599.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 70,241,331.00 | 60,122,599.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 20,565,800.00 | 21,800,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **100,894,190.00** | **158,010,900.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 100,894,190.00 | 158,010,900.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 100,894,190.00 | 119,937,700.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 38,073,200.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **285,439,525.00** | **104,389,042.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **38,828,500.00** | **78,663,500.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **38,828,500.00** | **78,663,500.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 38,828,500.00 | 78,663,500.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 38,828,500.00 | 78,663,500.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(38,828,500.00)** | **(78,663,500.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 246,611,025.00 | 25,725,542.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 43,259,557.00 | 289,870,582.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 289,870,582.00 | 315,596,124.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| D01 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **471,200,088.00** | **1,901,778,524.88** | **507,220.89** | **2,373,485,833.77** |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **471,200,088.00** | **1,901,778,524.88** | **507,220.89** | **2,373,485,833.77** |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 405,518,729.27 | 405,518,729.27 |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **471,200,088.00** | **1,901,778,524.88** | **406,025,950.16** | **2,779,004,563.04** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **4,353,958,145.00** | **4,019,501,909.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **4,353,958,145.00** | **4,019,501,909.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **4,195,947,245.00** | **3,861,491,009.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **3,237,016,800.00** | **3,040,414,424.00** |
| 210101 | Үндсэн цалин | 2,054,082,500.00 | 1,888,017,514.00 |
| 210102 | Нэмэгдэл | 1,055,969,300.00 | 1,048,242,962.00 |
| 210104 | Урамшуулал | 126,965,000.00 | 104,153,948.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **404,627,100.00** | **396,548,700.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 275,146,400.00 | 269,653,000.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 32,370,300.00 | 31,724,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 16,185,100.00 | 15,862,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 16,185,000.00 | 15,862,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 64,740,300.00 | 63,447,700.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **74,868,000.00** | **74,068,000.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 210301 | Гэрэл, цахилгаан | 12,124,000.00 | 12,787,957.00 |
| 210302 | Түлш, халаалт | 62,744,000.00 | 61,280,043.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **255,362,100.00** | **214,766,060.00** |
| 210502 | Хоол, хүнс | 255,362,100.00 | 214,766,060.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,300,000.00** | **2,300,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 2,300,000.00 | 2,300,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **57,544,195.00** | **45,434,455.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,102,500.00 | 6,102,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 51,441,695.00 | 39,331,955.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **164,229,050.00** | **87,959,370.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 140,378,950.00 | 65,509,370.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 23,850,100.00 | 22,450,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **158,010,900.00** | **158,010,900.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **158,010,900.00** | **158,010,900.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 119,937,700.00 | 119,937,700.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 38,073,200.00 | 38,073,200.00 |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **4,107,863,100.00** | **4,107,863,100.00** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **4,031,495,100.00** | **4,031,495,100.00** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 4,031,495,100.00 | 4,031,495,100.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **76,368,000.00** | **76,368,000.00** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 76,368,000.00 | 76,368,000.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 289,870,582.00 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 315,596,124.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **127.00** | **127.00** |
| 620001 | Удирдах ажилтан | 4.00 | 4.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 62.00 | 62.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 51.00 | 51.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | 10.00 | 10.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **127.00** | **127.00** |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 66.00 | 66.00 |
| 650006 | Соёл урлагийн салбарын төрийн їйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | 1.00 | 1.00 |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 1.00 | 1.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 49.00 | 49.00 |
| 650010 | Гэрээт ажилтан | 10.00 | 10.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тус байгууллагад нэмэлт данс байхгүй байна

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

*Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар*

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь бүрэн дунд боловсрол олгох чиг үүрэгтэй байгууллага. Сургууль нь 2024 онд “Цаг үргэлж сурч хөгжин, эрх үүргээ ухамсарласан, нэгэн зорилгын төлөө нэгдэж, эерэг харилцаа хандлагыг эрхэмлэсэн эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн хамтын оролцоог хангасан бүтээлч хамт олон болох” зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Дээрх зорилгыг биелүүлэхээр дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Нийт багш нарыг өөрсдийн хэрэгцээ сонирхлын дагуу судлагдахууны болон МХБ-ээр бүлэг үүсгэж ажиллуулах, хөгжүүлэх нөхцөл бололцоогоор хангах
- “Шинэ Монгол” менежментийг сайжруулах төсөлд хамт олноороо идэвх зүтгэл гарган оролцох, хөгжих.
- Багш, сурагчдын монгол хэлний мэдлэгийг сайжруулах чиглэлээр улирал бүр үйл ажиллагаа төлөвлөн зохион байгуулах.
- “Ур чадварын уралдаан”, “Багш солилцоо” хөтөлбөр, ажлын байрандаа мэргэжлээ дээшлүүлэх ур чадварт гарсан ахиц, үр дүнг тооцож ажиллах
- Бага, дунд, ахлах ангийн сурагчдын сурлагын хоцрогдол үүсэхгүй байхад анхаарч багш, эцэг эхтэй гэрээ байгуулан үр дүнг тооцож ажиллах.
- Сургууль, дотуур байрны орчин дахь хүүхэд хамгаалалын талаар улирал бүрийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа тогтмол зохион байгуулж, эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх.
- Сургууль, дотуур байрны үйл ажиллагаанд эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн “ Эцэг эхийн өдөрлөг”, “Нээлттэй хаалганы өдөр” зэрэг үйл ажиллагааг улирал бүр зохион байгуулах.
- Хөгжлийн ялгаатай хүүхдүүдийн хамран сургах үйл ажиллагааг дэмжлэгийн багтай хамтран хэрэгжүүлэх, багш нарыг чадавхжуулах, ганцаарчилсан сургалтын хөтөлбар боловсруулан хэрэгжүүлэх.
- ЭЕШ-ын дундаж оноог судлагдахуун тус бүр 5 оноогоор ахиулах
- Сонгон судлах хичээлийн цахим бүлэгт хамрагдсан сурагчид бие даан суралцах чадвар эзэмшүүлэх.
- Суралцагчдын хамтран суралцах, багаар ажиллах үйлийг дэмжин, ажиглалт туршилт, эрэл хайгуул хийх, өөртөө итгэлтэйгээр суралцах бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх “Төсөлт ажил” хэрэгжүүлж үр дүнг нээлттэй тайлагнах гэх мэт 27 зорилт дэвшүүлэн ажилласан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

***Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар***

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа Боловсролын тухай хууль, Бага дунд боловсролын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажилласан байна.

Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь сургуулийн захирлын 2019 оны 13 тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажилладаг байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны А/229 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 405.5 сая төгрөгөөр буюу 17.1 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 289,870.6 | 315,596.1 | 25,725.5 |
| Авлага | 32,602.0 | - | (32,602.0) |
| Бараа материал | 345,866.1 | 426,421.6 | 80,555.5 |
| Үндсэн хөрөнгө | 1,705,147.2 | 2,036,986.8 | 331,839.7 |
| **Нийт хөрөнгө** | **2,373,485.8** | **2,779,004.6** | **405,518.7** |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 2,373,485.8 | 2,779,004.6 | 405,518.7 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **2,373,485.8** | **2,779,004.6** | **405,518.7** |

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оноос мөнгөн хөрөнгө 315.6 сая төгрөг болж 25.7 сая төгрөгөөр өссөн байна.

Авлагын данс өмнөх онд цахим худалдан авалт хийж гэрээ байгуулсан компаниуд бараа үйлчилгээг гэрээний хугацаанд нийлүүлээгүйтэй холбоотой гарсан авлага болох 32.6 сая төгрөгийн авлагыг барагдуулж оны эцэст авлагагүй гарсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 426.4 сая төгрөг болж 80.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд улсын болон орон нутгийн төсвөөр хөрөнгө бий болсонтой холбоотой байна. Үүнийг тодруулж үзэхэд дараах байдалтай байна.

Төсвийн хөрөнгөөр 462.3 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, НҮБ-аас ариун цэврийн эрүүл мэндийн багц 11.6 сая төгрөг, аймаг, сумын ОНХСангаас бүгд 4.9 сая төгрөгийн аж ахуйн материал, аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 28.8 сая төгрөгийн зөөлөн эдлэл, аймгийн Боловсрол газраас 18.1 сая төгрөгийн түрээсийн сурах бичиг, сургуулийн туслах мал аж ахуйгаас 14.7 сая төгрөгийн төл бүгд 540.4 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч данс бүртгэлд тусгаж, 459.8 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2778.7 сая төгрөг болж 488.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд 78.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авч, өмнөх онд “Монголын цахилгаан холбоо” ХХК-иудаас өмнөх онд цахим худалдан авалт хийсэн боловч нийлүүлээгүй бүгд 32.6 сая төгрөгийн авлагыг хүлээн авсан ба 377.1 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч нийт 488.4 сая төгрөгийн барилгын сайжруулалт, машин, тоног төхөөрөмж, тавилга эд хогшилыг хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийг задалж үзэхэд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 170.1 сая төгрөгийн сургуулийн дотуур байрны засвар, 9.3 сая төгрөгийн тоног төхөөрөмж, аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр 43.5 сая төгрөгийн тавилга, эд хогшил, сумын ОНХС-гийн хөрөнгөөр сургуулийн өргөтгөлийн барилгын урсгал засвар 24.5 сая төгрөг, 9.2 сая төгрөгнийн машин тоног төхөөрөмж, БОАЖЯ-ны эко төслөөр бүгд 22.3 сая төгрөгийн тавилга эд хогшил, машин тоног төхөөрмж, НҮБ-аас 19.0 сая төгрөгийн, Боловсролын шинжлэх ухааны яамнаас 41.2 сая төгрөгийн, аймгийн Боловсролын газраас 38.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж бүгд 377.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс 325.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3028.0 сая, нийт зарлагыг 3028.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Улсын төсвийн төслийн саналаас зардлыг 997.4 зардлыг сая төгрөгөөр бууруулж 4025.4 сая төгрөгөөр баталсан байна.

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны анх батлагдсан төсөв 2781.7 сая төгрөг ба тодотгосон төсөв 4025.4 сая төгрөг болж анх баталснаас 1243.7 сая төгрөгөөр нэмж тодотгосон байна. Энэ нь Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор тайлант оны 7 дугаар сараас цалин нэмэгдсэнтэй холбоотой байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 15 арга хэмжээг санхүүжүүлэхээр 4025.4 сая төгрөгийг улсын төсвөөс, 76.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүгд 4101.8 сая төгрөгийн орлого санхүүжилтийг бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 4025.4 сая, орон нутгийн төсвөөс 76.4 сая төгрөгийн санхүүжилт авч, урьд оны үлдэгдлээс 289.9 сая төгрөг санхүүжүүлж бүгд 4391.6 сая төгрөгийн орлого санхүүжилтээр үйл ажиллагаа явуулсан байна.

Төсвийн зарлагын нийт гүйцэтгэл 4085.0 сая төгрөг буюу 93.0 хувьтай буюу дансанд 315.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Төсвийн харилцах дансанд их хэмжээний мөнгөний үлдэгдэлтэй гарсан нь төсвийн төлөвлөлт, хуваарилалттай холбоотой байна.

Нийт төсвийн зарлагын 84.1 хувийг цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 5.3 хувийг тогтмол зардал, 1.8 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 1.0 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, 3.9 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 3.9 хувийг бусад урсгал шилжүүлэг тус тус эзэлж байна.

Цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 3040.4 сая, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 396.5 сая, норматив зардлыг 214.7 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 74.1 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 39.3 сая, бараа үйлчилгээний бусад зардал 159.6 сая, бусад урсгал шилжүүлэг 158.0 сая бүгд 306.6 сая төгрөг хэмнэсэн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 80226 | Байр ашиглалтын үйлчилгээ | 7,812.5 | 5,052.0 | 2,760.6 | 64.7 |
| 2 | 80233 | Хүүхэд хамгаалал | 6,272.0 | 4,686.4 | 1,585.6 | 74.7 |
| 3 | 80312 | Сургалт семинар | 5,073.2 | 4,342.5 | 730.7 | 85.6 |
| 4 | 81605 | Эрүүл мэндийг дэмжих | 11,341.7 | 1,820.0 | 9,521.7 | 16.0 |
| 5 | 81801 | үдийн цай хөтөлбөр | 119,937.7 | 119,937.7 | - | 100.0 |
| 6 | 81806 | Дотуур байрны үйлчилгээ | 955,727.8 | 886,880.8 | 68,847.0 | 92.8 |
| 7 | 81816 | Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 53,223.5 | 53,223.5 | - | 100.0 |
| 8 | 81823 | Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх | 22,655.4 | 5,960.0 | 16,695.4 | 26.3 |
| 9 | 81827 | Бичиг үсгийн боловсролын хөтл | 16,705.2 | 16,284.8 | 420.4 | 97.5 |
| 10 | 81834 | Боловсролын стандарт, сургалты | 2,903,886.0 | 2,717,873.3 | 186,012.7 | 93.6 |
| 11 | 81835 | Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 194,166.5 | 187,416.8 | 6,749.7 | 96.5 |
| 12 | 81844 | Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн | 25,521.1 | - | 25,521.1 | - |
| 13 | 81875 | Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх | 10,461.6 | 5,180.5 | 5,281.1 | 49.5 |
| 14 | 83603 | Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан | 1,000.0 | 1,000.0 | - | - |
| 15 | 80111 | Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 77,168.0 | 76,368.0 | 800.0 | 99.0 |
| | | **Дүн** | **4,410,952.2** | **4,086,026.1** | **324,926.1** | **92.6** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлийн судалгааны дүн дараах байдалтай байна. Үүнд:

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь Ахмадын тухай хууль, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор баталсан “Ахмадын сан ажиллуулах журам”-ыг хэргжүүлээгүй буюу ахмадын сах байгуулж ажиллаагүй байна.

Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гаргаж ажиллаагүй байна.

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас 6.1 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлын дансаар 60.7 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2018 оны А/024/11 дүгээр тушаалаар баталсан төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны жишиг оронд багтаан ажиллаж ирсэн байна.

Тус газрын 1-12 дугаар сарын цалин олгох хүснэгтээр 126-128 хүн цалин хөлс олгож ирсэн байна. Байгууллагын 2024 оны орон тооны судалгааг гаргуулан авч хянаж үзэхэд аймгийн засаг даргын захирамжаар 127 орон тоогоор батлагдсан боловч 128 орон тоогоор ажиллаж 1 орон тоог илүү байна. Үүнийг тодруулж үзэхэд ангил хэлний цагийн багшийн орон тоогоор илүү байна.

Боловсролын үнэлгээний төвөөс ирүүлсэн багш болон байгууллагын 2024 оны үнэлгээний дагуу индексийн 1-4 дүгээр түвшнд үнэлэгдсэн 45 багшид 3 сарын урамшуулалт цалинг зохих журмын дагуу олгосон байна.

Болвсролын ерөнхий газрын 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/389, 2024 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/355 дугаар “сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгийн нэмэлт урамшууллын санхүүжилт олгох тухай” тушаалаарууудаар Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуульд нийтдээ 58.6 сая төгрөгийн урамшууллын санхүүжилт олгосон байна.

Дээрх Болвсролын ерөнхий газраас ирүүлсэн гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллын санхүүжилтийг Засгийн газрын 2024 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолд баталсан журмын дагуу, сургуулийн багш нарын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн зохих журмын дагуу хуваарилж зарцуулсан байна.

**3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

***3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн***

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2024 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

**3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

2024 онд цахим худалдан авалтаар 48.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авч данс бүртгэлд тусгасан байна.

## АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Манаргүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 04 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 4167.6 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 62.5 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзэв

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой төсвийг хэмнэх талаар 29 арга хэмжээний хэрэгжилтийг шалгаж үзэхэд алдаа зөрчил илрээгүй байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2024 онд нийт 2710.7 сая төгрөгийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилт 100 хувь байна. Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн шийдвэрийг байршуулсан байна.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн төсвийн зарцуулалт нь Төсвийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар нийт 33.3 сая төгрөгийн зөрчил илэрснээс 33.3 сая төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлсэн. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг давтан шалгаж үзэхэд бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 1 | 33.3 | 1 | 33.3 | 100% |
| Нийт дүн | **1** | **33.3** | **1** | **33.3** | 100% |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах зүйл гараагүй.Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалж тус байгууллагын санхүүжилтийн зарцуулалтын тооцоог бүрэн шалгах боломжгүй тул эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

### 5.1 Төлбөрийн акт

Тогтоосон төлбөрийн акт байхгүй

### 5.2 Албан шаардлага

Аудитын дүнгээр 2513.0 мянган төгрөгийн албан шаардлага өгөгдлөө.

1. Ногооннуур сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн "Төсөв, санхүүгийн ажилтан нарт балансын урамшуулал олгох тухай" А/58 дугаар тушаалаар нягтлан бодогч, нярав нарт 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчилгүй дүгнэлт авсан гэж бүгд 2513.0 мянган төгрөгийн урамшуулал олгож, төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын хэмжээг хэтрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 6.4.1-д "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", 16 дугаар зүйлийн 16.5-д "*Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ*", 16.5.5-т "*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*", Засгийн газрын 2019 оны "Журам батлах тухай" 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> 1. Төрийн албан хаагчид олгох мөнгөн урамшууллыг холбогдох хууль, журам зөрчиж тогтоосон хэмжээнээс хэтрүүлэн олгохгүй байх

**5.3 Зөвлөмж**

***1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

*<u>1.1. Илрүүлэлт:</u>*

Сургууль нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй /дотуур байрны хоол хүнс 214.7 сая төгрөг, үдийн хоол 119.9 сая төгрөг г.м/ байна.

*<u>1.2 Өгсөн зөвлөмж</u>:*

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44.1-т Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.", 46.1-т "Захиалагч худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан төсөл, арга хэмжээ бүрээр харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр тайлагнана." гэсэн заалттай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*<u>2.2 Өгсөн зөвлөмж</u>*: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлж ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| ДҮН | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Хууль журам зөрчиж олгосон | 1 | 2513.0 | | | 1 | 2513.0 | | | | | | |
| Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, тайлагнаагүй. | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| **Дүн** | **2** | **2513.0** | | | **1** | **2513.0** | **1** | **0** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | |
| Төрийн хэмнэлттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| **Нийт дүн** | | | | | | | | |